



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 88,675,605 /наян найман сая зургаан зуун далан таван мянга зургаан зуун тав/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 7,316,440 /долоон сая гурван зуун арван зургаан мянга дөрвөн зуун дөч/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 95,992,045 /ерэн таван сая есөн зуун ерэн хоёр мянга дөчин тав/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолоор “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Дарханы дулааны сүлжээ” ХК /Б.Алтанцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000186